

Тайлангийн маягт, хавсралт мэдээ,
нөхөх заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хлбаршуулсан тайлан”-гийн маягт /ТТ-02-ХГ/-ыг 1 дүгээр, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хялбаршуулсан тайлангийн маягтыг нөхөх заавар”-г 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний загварыг Татварын удирдлагын нэгдсэн системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д даалгасугай.

3. Батлагдсан маягтын дагуу тайланг хүлээн авч, татварын тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



Татварын ерөнхий газрын даргын
20... оны ... сарын ... -ны өдрийн
... дугаар тушаалын ... хавсралт

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА Маягт ТТ-02-ХГ

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХЯЛБАРШУУЛСАН ТАЙЛАН

ТТ-ийн дугаар:
ТТ-ийн нэр: _____
Тайлант хугацаа: он улирал

Утас:
Факс:

Тухайн тайлант хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй бол энд тэмдэглэнэ үү.

(оны эхнээс өссөн дүнгээр,

төгрөгөөр)

Үзүүлэлтүүд	Мөр	Дүн
I	II	III
А. Хялбаршуулсан горим ашиглан ногдуулах албан татварын тооцоолол:		
1. Үйл ажиллагааны нийт орлого (2+3+4+5+6)	1	
1.1. Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого	2	
1.2. Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлого	3	
1.3. Техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого	4	
1.4. Үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого	5	
1.5. Дээрхтэй адилтгах бусад үйл ажиллагааны орлого	6	
2. Татвар ногдуулах орлого (мөр 1)	7	
3. ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (7* хуулийн 29.9-д заасан хувиар)	8	

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Захирал /дарга/

Татварын улсын байцаагч

Ерөнхий нягтлан бодогч

Итгэмжлэгдсэн нягтлан бодогч /...../

Татварын тайлан, хавсралт мэдээг
Татварын удирдлагын нэгдсэн системээс
үүсгээсэн кодоор баталгаажуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хялбаршуулсан тайлангийн маягтыг нөхөх заавар

Энэхүү тайлангийн маягтаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 29 дүгээр зүйлийн 29.13-т заасны дагуу албан татвар төлөгч нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хялбаршуулсан тайлан /цаашид “тайлан” гэх/-г дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор өссөн дүнгээр жилд 1 удаа гаргаж, харьяалах татварын албанд хүргүүлнэ.

Тайланг гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ыг баримтална. Тайлангийн 3 дугаар баганад тухайн үзүүлэлтийн дүнг өссөн дүнгээр, төгрөгөөр бөглөнө.

Нэг.Хялбаршуулсан горим ашиглан ногдуулах албан татварын тооцоолол

1.Үйл ажиллагааны нийт орлого буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2, 3, 4, 5, 6 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.

2.Бараа, ажил, үйлчилгээний борлуулалтын орлого буюу 2 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.1-д заасан орлогын дүн байна.

3.Төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны үйл ажиллагаанаас олсон орлого буюу 3 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.2-т заасан орлогын дүн байна.

4.Техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого буюу 4 дүгээр мөрийн дүн нь хуулийн 8.1.3-т заасан орлогын дүн байна.

5.Үнэ төлбөргүйгээр бусдаас авсан бараа, ажил, үйлчилгээний орлого буюу 5 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.4-т заасан орлогын дүн байна.

6.Дээрхтэй адилтгах бусад үйл ажиллагааны орлого буюу 6 дугаар мөрийн дүн нь хуулийн 8.1.5-д заасан орлогын дүн байна.

7.Татвар ногдуулах орлого буюу 7 дугаар мөрийн дүн нь 1 дүгээр мөрийн дүнтэй тэнцүү байна.

8.Төлбөл зохих албан татвар буюу 8 дугаар мөрийн дүн нь 7 дугаар мөрийн дүнг хуулийн 29.9-д заасны дагуу албан татвар ногдуулах орлогыг 1 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР